

САРААНА БАЙГАЛЬ ХАМГААЛАХ САНГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Зорилго:

Монгол орны зэрлэг байгаль, биологийн олон янз байдал, тэдгээрийн хамгаалал болон нөөцийн тогтвортой хэрэглээг ирээдүй хойч үедээ шинжлэх ухааны судалгаа, хамгаалал, боловсролоор дамжуулан сурталчлан таниулж, хадгалан хамгаалж, өвлүүлэн үлдээх.


Үйл ажиллагаанууд:

1. Сонгинохайрхан уул, Хун нуур орчмын ус намгархаг газрын биологийн олон янз байдлын судалгаа

СХУ, Хун нуур орчмын ус намгархаг газар нь амьтан, ургамалд чухал ач холбогдолтой газар бөгөөд олон зүйлийн шувуудын үржих, амрах, нүүдлийн үеэр дайран өнгөрөх гол газар болдог ба манай хоттой хамгийн ойр орших биологийн олон янз байдлаар баялаг ус намгархаг газар юм. Бид тус газар нутагт одоогийн байдлаар шувуу, ургамал, замагны мониторингийн судалгааг эхлүүлээд байгаа бөгөөд 2022 оноос бусад чиглэлийн судалгаануудыг хийхээр төлөвлөн ажиллаж байна.



Хун нуур



Замаг сээр нуруугүй амьтны судалгаа

2. Дэлхийн нүүдлийн шувуудын өдөр

Дэлхийн нүүдлийн шувуудын тэмдэглэлт өдөр 5, 10-р сард болдог бөгөөд ДНШӨ-ийг тохиолдуулан “Хун нуурын шувуудаа хамгаалъя” уриан дор Хун нуур, түүний ойр орчмыг цэвэрлэх сайн дурын аяныг жил бүр 2 удаа зохион байгуулахаар төлөвлөж, тус аяныг 10-р сарын 10-ны өдөр эхлүүлэн СХД-ЗДТГ, Нийслэлийн байгаль орчны газар, Олон улсын худалдаа логиستيкийн төв ХК, бусад байгууллагуудын төлөөлөл, оюутан залуустай хамтран Хун нуураа цэвэрлэлээ.



3. Хун нуурын эко аялал

Урбан экологи, ус намгархаг газар, түүний биологийн олон янз байдлыг хамгаалах шинжлэх ухаан, танин мэдэхүйн эко аяллуудыг зохион байгуулж, олон нийт, сургуулийн сурагчдад хүргэхээр төлөвлөн ажиллаж байна. Бид Хун нуурын эко аяллыг өөрсдийн гүйцэтгэж буй судалгааны ажлын үр дүнд тулгуурлан хүүхдүүд, олон нийтэд таниулах ажлуудыг энэ жил эхлүүлээд байна.

4. Махчин шувууд, Шувуулахуйтай танилцах сургалт

ЕБС-нуд болон албан байгууллагуудад зориулан махчин шувууд, тэдгээрийн экологи, биологи, хамгаалал, ЮНЕСКО-н Соёлын биет бус өв соёлоор бүртгэгдсэн Шувуулахуйн уламжлалт өв соёлыг таниулах сургалтуудыг явуулж байна.



ТАЛАРХАЛ:

Бидний ажлыг дэмжин ажиллаж байгаа Нийслэлийн Байгаль Орчны Газар, СХД-ийн ЗДТГ, ОУ-ын худалдаа логиستيкийн төв ХК, Монголын шувуулахуйн холбоо, Монголын амьтан сургагчдын холбоонд талархал илэрхийлье.

Зохион байгуулагч:
САРААНА БАЙГАЛЬ
ХАМГААЛАХ САН



Нуурыг тойрох
нийт урт: 3.5 км
Аялал үргэлжлэх
хугацаа: 2 цаг
Өдөр: 2021.10.23
Эхлэх цаг: 10:00



ХУН НУУРЫН ЭКО АЯЛАЛ

ХҮҮХДҮҮДЭЭЙ!

ЭКОЛОГИЙН
МЭДЛЭГ ОЛГОХ
ӨДӨРЛӨГ

Хот суурин газрын ус намгархаг газар болон амьтан, ургамал, тэдгээрийн байгальд гүйцэтгэх үүрэг, хамгааллын ач холбогдол, шинжлэх ухаан танин мэдэхүйн мэдээллийг эко аяллаас аваарай.

АЯЛТЫН ТАСАЛБАР: 3000 ТӨГ.
Энэ аяллаас олсон орлого Хун нуурын биологийн олон янз байдлын судалгаанд зарцуулагдана.



Урбан экологи, ус намгархаг газрын талаар мэдэж авах



Шувуу ажиглах, тодорхойлж, сурал



Загастай танилцах



Усны сээр нуруугүй амьтантай танилцах



Усны ургамалтай танилцах



Замагтай танилцах



Махчин шувуу харж, зургаа дариулах

САРААНА БАЙГАЛЬ ХАМГААЛАХ САН

Хаяг: БЗД, 16-р хороо, 16-р хороолол,
Батлан хамгаалах их сургуулийн баруун талд
9-р байр 31 тоот.
Имэйл хаяг: info.snfc21@gmail.com
Фэйсбүүк: Saraana nature conservation foundation
Утас: 80004649; 80884649

ХУН НУУРЫН ЭКО АЯЛАЛ



ЗОРИЛГО: Хот суурин газрын ус намгархаг газар, түүний ургамал, амьтны шинжлэх ухаан, танин мэдэхүйн мэдлэг олгох.

ХУН НУУРЫГ ТОЙРОН АЛХАХ АЯЛЛЫН МАРШРУТ

Та агаарт алхангаа шинжлэх ухаан, танин мэдэхүйн мэдээлэл авч, хүрээлэн буй орчин, экологийн мэдлэгээ ахиулаарай.



Ус намгархаг газартай танилцах цэг

Энэ цэг дээр та бүхэн Сонгинохайрхан уул, Хун нуур орчмын ус намгархаг газрууд, тэдгээрийн Урбан экологид гүйцэтгэх үүрэг, ач холбогдол, танин мэдэхүйн мэдээллүүдийг авч, аяллын талаарх заавартай танилцана.



Шувуутай танилцах 1-р цэг

Хун нууранд олон зүйлийн нүүдлийн, суурин шувуудыг ажиглан харж, зураг дарах боломжтой бөгөөд та энэ цэг дээр нуурын түгээмэл шувуудыг ажиглан, тодорхойлж сурна.



Усны ургамалтай танилцах 1-р цэг

Хун нуур, түүний ойр орчмын ус намгархаг газрын ургамлын танин мэдэхүйн мэдээлэл авахаас гадна нууранд түгээмэл ургадаг усны ургамлыг ажиглан, холбогдох мэдээллүүдийг авах.



Сээр нуруугүй амьтан, загастай танилцах цэг



Энэ цэг дээр та бүхэн сээр нуруугүй болон сээр нуруутай амьтдын хоорондын ялгаа, хэрхэн таних талаар мэдээлэл авахаас гадна нууранд түгээмэл тохиолддог шаймий хавч хэлбэртэн, хануур хорхой болон загасны зарим зүйлүүдтэй таницана.



Шувуутай танилцах 2-р цэг

Шувуудын гадаад содон шинж тэмд гээр шувуудыг хэрхэн таньж тодорхойлдог, шувуудын өнгө зүсний ялгаа, нүүдлийн махчин шувуудын талаар танин мэдэхүйн мэдээлэл авч. Нуурын шувуудыг ажиглан, дэлхийн хамгийн хол замыг туулан нүүдэллэдэг махчин шувуутай танилцаж, зургаа даруулах.



Усны ургамалтай танилцах 2-р цэг

Ус намгархаг газрын экосистемд чухал үүрэг гүйцэтгэдэг Зэгс, Жагмаа зэрэг усны ургамлуудтай танилцан ажиглаж, холбогдох танин мэдэхүйн мэдээллүүдийг авна. Мөн ургамлын хатаадасыг хэрхэн бэлтгэх талаар мэдээлэл авч, ургамлын хатаадас бэлтгэж сурна.



Замагтай танилцах цэг

Замаг гэж ургамал мөн эсэх дээр ихэнх хүмүүс янз бүрийн ойлголттой байдаг. Тэгвэл энэ цэг дээр та нууранд тохиолдох замагуудыг ажиглаж, хэрхэн тодорхойлдог талаар мэдэж авахаас гадна нуурын замагны талаарх мэдлэгээ ахиулна.



Махчин шувуудтай танилцах цэг

Та энэ цэг дээр махчин шувууд, тэдгээрийн байгальд гүйцэтгэх үүрэг, ЮНЕСКО-н соёлын биет бус өв соёл болох Шувуулахуйн талаар мэдээлэл авч олон зүйлийн махчин шувуудтай танилцаж, зургаа даруулах боломжтой.